

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагааг болон түүнийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавихад шаардлагатай бүх төрлийн мэдээллээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг /цаашид Зөвлөл гэнэ/ хангахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Зөвлөлийг мэдээллээр хангах үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хууль бусад хууль тогтоомж болон энэхүү журмын дагуу зохион байгуулна.

1.3 Энэхүү журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2-т зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөнө.

Хоёр. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах

2.1 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу Зөвлөлийг мэдээллээр хангах үүргийг төрийн холбогдох байгууллагууд хүлээнэ.

2.2 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 9.3-т заасны дагуу байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ, түүний үр дүнг тогтоосон хугацаанд хариу мэдээлэх үүрэгтэй.

2.3 Зөвлөл нь шаардлагатай бол үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлыг хөндсөн тодорхой асуудлаар төрийн бус байгууллагаас хэрэгцээтэй мэдээлэл гаргуулан авч болно.

2.4 Олон улсын хэмжээнд болон улс орны дотор онцгой байдал бий болсон үед төрийн байгууллагууд Зөвлөлийг байнгын мэдээллээр хангаж, мэдээллийн дагуу авах арга хэмжээг Зөвлөлийн ажлын алба уялдуулан зохицуулна.

2.5 Онцгой яаралтай тохиолдолд шаардлагатай мэдээг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын албаны дарга, чиглэл хариуцсан референт болон Мэдээлэл, дүн шинжилгээний албаны шинжээч нарт утсаар эсхүл биечлэн дамжуулж, дараа нь баримтжуулна.

Гурав. Мэдээллийн ангилал, хугацаа

3.1 ҮАБЗ-д ирүүлэх мэдээлэл нь шинж чанараасаа хамааран яаралтай мэдээ, шуурхай мэдээ, танилцуулах мэдээ, танилцуулах тойм мэдээ, тайлан гэсэн ангилалтай байна. Үүнд:

3.1.1 **яаралтай мэдээ** гэж үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлалд хохирол учруулахуйц үйл явдлын тухай мэдээ болон Зөвлөлөөс албан хэрэгцээнд нэн даруй ирүүлэхийг шаардсан мэдээг,

3.1.2 **шуурхай мэдээ** гэж тухайн үед болсон үйл явдал, хэргийн талаарх мэдээллийг,

3.1.3 **танилцуулах мэдээ** гэж үйл явдлын товч танилцуулга, тодорхой санал бүхий мэдээллийг,

3.1.4 **танилцуулах тойм мэдээ** гэж тодорхой хугацааны үйл явдлыг тоймлож, түүний явц, өрнөлд үнэлэлт, дүгнэлт өгсөн, цаашид авах арга хэмжээний саналыг тусгасан,

3.1.5 **тайлан мэдээ** гэж үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг тухайн салбар, байгууллагын хүрээнд хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлсэн, гарсан үр дүнгийн тухай тайланг тус тус ангилна.

3.2 Эх үүсвэрээр нь гадаад, дотоод мэдээлэл гэж ангилна.

3.3 Яаралтай мэдээг тухайн үйл явдал болмогц цаг алдалгүй нэн даруй утсаар мэдээлж, дараа нь бичгээр баталгаажуулна. Онц яаралтай мэдээг Зөвлөлийн нарийн бичгийн даргад нэн даруй танилцуулна.

3.4 Тухайн цаг хугацаанд болсон үйл явдал, хэргийн талаарх шуурхай мэдээ, мэдээллийг Ажлын албанд 12 цагийн дотор ирүүлж 24 цагийн дотор Зөвлөлд танилцуулсан байна.

3.5 Хавсралтад заагаагүй танилцуулах мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан шаардлагатай тохиолдолд гаргаж Зөвлөлийн Ажлын албанд ирүүлж байна.

3.6 Үндэсний аюулгүй байдал тухайн чиглэлээр хэрхэн хангагдаж байгаа тухай илтгэлийг Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан байгууллагууд хагас жилд нэг удаа, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд жил бүр Зөвлөлд ирүүлнэ.

3.7 Өдөр тутмын шуурхай мэдээг дараа өдрийн 10.00 цагаас өмнө Зөвлөлд танилцуулсан байна.

3.8 “Тухай бүр” гэснээс бусад танилцуулах мэдээллийг дараа сар, улирлын эхний долоо хоногийн ажлын өдөрт багтааж ирүүлнэ.

3.9 Танилцуулах тойм мэдээ, тайлангийн хагас жилийнхийг 7 дугаар сарын 2 дугаар долоо хоногт, бүтэн жилийнхийг дараа оны 2 дугаар сарын эхний долоо хоногт багтаан ирүүлнэ.

Дөрөв. Мэдээ, мэдээлэл ирүүлэх

4.1 Зөвлөлд ирүүлэх төрийн нууцтай холбоотой мэдээллийг боловсруулах, илгээх, хүлээн авах, ашиглахдаа Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцыг хамгаалах журмын дагуу гүйцэтгэнэ.

4.2 Илгээгч байгууллага мэдээллийн агуулгаас шалтгаалан уг мэдээллийг нууцлах эсэхийг шийдвэрлэх ба нууцын зэрэглэлийг тогтоох, ирүүлэхдээ Төрийн нууцын тухай хуулийг баримтална.

4.3 Төрийн байгууллагууд энэ журмын хавсралтад заасан мэдээллийг “Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Ажлын албанд” гэж хаяглан бичгээр, нэг хувь ирүүлнэ.

4.4 Мэдээллийг яам, агентлаг, тусгай газар, орон нутгийн байгууллагын /төрийн нарийн бичгийн дарга, төрийн болон орон нутгийн захиргааны удирдлагын газар, хэлтэсийн/ дарга нар энэ журмын хавсралтад заасан хугацаанд ирүүлнэ.

4.5 Төрийн байгууллагууд шаардлагатай үед энэ журмын хавсралтад заагдаагүй мэдээлэл, судалгааг Зөвлөлийн даалгавар, чиглэлийн дагуу Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 12, 13, 14, 17 зүйлд заасны дагуу ирүүлнэ.

4.6 Гүйцэтгэх ажил эрхэлдэг тусгай албад үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг холбогдох хууль, зохих журмын дагуу Зөвлөлд тогтмол ирүүлнэ.

4.7 Үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий асуудлуудаар стратегийн шинжтэй судалгаа хийж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мөн Зөвлөлийн шинжээчид хийсэн судалгааны материалаа Зөвлөлийн Ажлын албанд ирүүлнэ.

4.8 Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой сэдвээр хэвлэгдсэн өгүүлэл, ном, судалгааны тайлан, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлийг тухайн салбарын шинжлэх ухаан технологи хариуцсан нэгжээс тухай бүр ирүүлнэ.

4.9 Зөвлөлд ирүүлэх мэдээллийг Төрийн холбооны шуудангаар хүргүүлнэ.

4.10 Зөвлөлд нэн яаралтай хүргүүлэх шаардлагатай гэж үзсэн мэдээ, мэдээллийг тусгайлан томилогдсон албан тушаалтнаар биечлэн хүргүүлж болно. Мөн төрийн холбооны газраас баталгаажуулсан электрон холбооны хэрэгсэл ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд Зөвлөлийн Ажлын албаны бичиг хэргийн эрхлэгч /нууц хариуцсан ажилтан/ ирүүлсэн мэдээллийг хүлээж авсан тухай тэмдэглэл хийж, нэгдсэн бүртгэлд авна.

4.11 Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон хавсралтад заасан төрийн ба орон нутгийн байгууллагууд хоногийн хугацаанд улс орны хэмжээнд болсон онцгой үйл явдал болон цаг үеийн нөхцөл байдлын тухай Зөвлөлийн Ажлын албаны Мэдээлэл, дүн шинжилгээний албанд өдөр бүр шуурхай мэдээлэл ирүүлж байна.

Тав. Мэдээллийг хүлээн авах, бүртгэх, танилцуулах, хадгалах

- 5.1 Зөвлөлийн Ажлын алба мэдээллийг өдөр тутам нэгтгэн Зөвлөлийн тэргүүн, гишүүдэд цаг тухайд нь танилцуулна.
- 5.2 Зөвлөлийн Ажлын албаны нэгдсэн бүртгэлд авагдсан мэдээллийг байгууллага, албан тушаалтанд танилцуулах ажлыг Зөвлөлийн нарийн бичгийн даргын шийдвэрийн дагуу гүйцэтгэнэ.
- 5.3 Зөвлөлд ирсэн нууц мэдээллийг хувилах, бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг зөвхөн Зөвлөлийн нарийн бичгийн дарга шийдвэрлэнэ.
- 5.4 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд авсан мэдээ, мэдээллийг албан тушаалтанд танилцуулах, ашиглуулах, эргүүлэн татах, хадгалах ажлыг Зөвлөлийн Ажлын албаны бичиг хэргийн зааварлагч-операторч /нууцын ажилтан/ биечлэн хариуцна.
- 5.5 Зөвлөлд ирүүлсэн мэдээ, мэдээллийг Ажлын албаны нэгдсэн бүртгэлд авч хадгална.
- 5.6 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд авсан мэдээ, мэдээллийг Төрийн нууцын тухай болон Архивын тухай хуулиар тогтоосон нөхцөлд хадгалах боломжоор Зөвлөлийн Ажлын алба хангагдана.

Зургаа. Хариуцлага тооцох

- 6.1 Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу мэдээлэл нь үнэн бодит, цэгцтэй, товч байх ба мэдээлэл, дүн шинжилгээний чанарыг холбогдох албан тушаатан, түүний шууд удирдлага хариуцна.
- 6.2 Зөвлөлийг энэхүү журамд заасан хугацаанд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үүргээ биелүүлээгүйгээс Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд цаг хугацаа алдах болон бусад эрсдэлийг бий болгосон албан тушаалтанд дээд шатны удирдах албан тушаалтан холбогдох хуулийн хүрээнд хариуцлага тооцож, Зөвлөлийн Ажлын албанд мэдэгдэнэ.

--- оОо---

**Төрийн байгууллагуудаас Үндэсний аюулгүй байдлын
Зөвлөлд ирүүлэх мэдээллийн ангилал, хугацаа**

Д/д	Байгууллага	Мэдээлэл	Ангилал	Хугацаа
Нэг: Улсын Их Хурлын харъяа байгууллагууд				
1.1	Улсын Их Хурлын Тамгын газар	Хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтийн тухай мэдээ ҮАБЗ-ийн хуралдаанаас УИХ-д хандан гаргасан зөвлөмж, чиглэлийн биелэлт УИХ-ын харьяа байгууллагын ҮАБ хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл. УИХ-ын судалгаа, шинжилгээний нэгжийн мэдээ, нийтлэлүүд.	Танилцуулах мэдээ Танилцуулах мэдээ Тайлан мэдээ Тайлан мэдээ	Тухай бүр Хагас жил Хагас жил Тухай бүр
1.2	Үндэсний аудитын газар	Хяналт шалгалтын ажлын явцад илрүүлсэн, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй зөрчил дутагдлын тухай мэдээ	Танилцуулах мэдээ	Тухай бүр
1.3	Үндэсний статистикийн хороо	Статистикийн мэдээ Эдийн засгийн аюулгүй байдал хэрхэн хангагдаж буй талаар судалгаа мэдээ	Танилцуулах мэдээ Танилцуулах тойм мэдээ	Сар бүр Хагас жил тутам
1.4	Монгол банк	Банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаа, төрийн мөнгөний бодлогод сөрөг нөлөөтэй хүчин зүйлсийн тухай мэдээ Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийн мэдээ	Танилцуулах мэдээ Танилцуулах мэдээ	Улирал бүр Улирал бүр

		<p>Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай мэдээ</p> <p>Монгол Улсын гадаад валютын нөөцийн мэдээ, импортийн хэрэгцээг хангах хугацаа /хоногоор/</p> <p>Арилжааны банкуудын үйл ажиллагааны тухай судалгаа, мэдээ</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Улирал бүр</p> <p>Улирал бүр</p> <p>Улирал бүр</p>
1.5	Санхүүгийн зохицуулах хороо	<p>Арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны тухай судалгаа мэдээлэл</p> <p>Үнэт цаасны арилжааны мэдээ</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Улирал бүр</p> <p>Улирал бүр</p>
1.6	Хүний эрхийн Үндэсний комисс	<p>Хүний эрх, эрх чөлөө ноцтойгоор зөрчигдсөн мэдээ</p> <p>Эрх, эрх чөлөө нь зөрчигдөж тусламж хүссэн иргэдийн судалгаа, танилцуулга</p> <p>Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан</p>	<p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Улирал бүр</p> <p>Жил бүр</p>
1.7	Авилгатай тэмцэх газар	<p>Авилгатай тэмцэх газарт хөрөнгө орлогын мэдүүлгээ өгдөг төрийн албан тушаалтны үйлдсэн авилгын гэмт хэргийн мэдээ</p> <p>Авилгын гэмт хэргийн илрүүлэлтийн мэдээ</p> <p>Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц байдал</p>	<p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Хагас жил тутам</p> <p>Жил бүр</p>
1.8	Төрийн албаны төв байгууллага	<p>Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо, судалгаа</p> <p>Хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн төрийн албан хаагчдад авсан арга</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Жил бүр</p> <p>Хагас жил</p>

		хэмжээ, шийдвэрийн талаарх мэдээ		тутам
Хоёр: Засгийн Газрын харьяа байгууллагууд				
2.1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	<p>ҮАБЗ-ийн хуралдаанаас Засгийн газарт өгсөн зөвлөмж, чиглэлийн биелэлт</p> <p>Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт</p> <p>Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгийн мэдээ</p> <p>Засгийн газрын харьяа байгууллагуудын ҮАБ хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл</p> <p>Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа</p> <p>ХДХВ/ДОХ-оос сэргийлэх чиглэлээр баримталж буй бодлого чиглэл, Үндэсний стратеги төлөвлөгөөний хэрэгжилт</p>	<p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Улирал тутам</p> <p>Жил бүр</p> <p>Тухай бүр, Хагас жил</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p>
2.2	Тагнуулын ерөнхий газар	<p>Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал, хүчин зүйлс, тэдгээрээс сэрэмжлэх арга хэмжээний санал бүхий мэдээ</p> <p>Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын товч тайлан</p> <p>Тагнуулын байгууллагын харьяаллын хэргийг илрүүлэн шийдвэрлэсэн ажлын тайлан</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p>
2.3	Төрийн өмчийн хороо	<p>Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын тухай танилцуулга</p> <p>Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тухай тайлан</p> <p>Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гадаад , дотоодод гаргасан үнэт цаас, арилжааны гэрээ, хэлэлцээрийн мэдээ</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Хагас жил тутам</p> <p>Тухай бүр</p>

		Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд үндэсний жижиг дунд үйлдвэрүүдийг хоршуулан ажиллуулж буй тухай мэдээ	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
2.4	Мэдээлэл, шуудан харилцаа, холбооны технологийн асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>Мэдээллийн салбарт хэрэгжүүлж буй олон улсын төслийн явцын тухай мэдээлэл</p> <p>Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлын мэдээ</p> <p>Мэдээлэл, харилцаа холбооны салбарын томоохон төслүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд үндэсний жижиг дунд үйлдвэрүүдийг хоршуулан ажиллуулж буй тухай мэдээ</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p>
2.5	Харилцаа холбооны зохицуулах хороо	<p>Харилцаа холбооны зохицуулалтын талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд тухай мэдээлэл.</p> <p>Мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулах эрх авсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн тухай мэдээлэл</p> <p>Тусгай зөвшөөрөл, стандарт, баталгаажуулалтын талаарх мэдээ</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Улирал тутам</p> <p>Тухай бүр</p> <p>Жил тутам</p>
2.6	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо	<p>Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, урт, дунд хугацааны стратегийн хэрэгжилтийн талаархи мэдээлэл,</p> <p>Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хагжлийн цогц бодлогын хэрэгжилтийн талаархи мэдээлэл болон төсөл бүрийн хэрэгжилт</p> <p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт /тухайн жил бүрээр/</p> <p>Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгасан “Технологи” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Улирал тутам</p> <p>Улирал тутам</p> <p>Улирал тутам</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p>

		Эдийн засгийн томоохон төслүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд үндэсний жижиг дунд үйлдвэрүүдийг хоршуулан ажиллуулж буй тухай мэдээ		
2.7	Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	<p>Цацраг идэвхт ашигт малтмал, ховор элементийн хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл</p> <p>Цөмийн эрчим хүчний үйлдвэрлэл, цөмийн материалын боловсруулах үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл</p> <p>Цацраг идэвхт ашигт малтмал, ховор элементийн нөөц, үнэ, зах зээлийн судалгаа</p> <p>Цацраг идэвхт бодисын хадгалалт, ашиглалт, цацрагийн хамгаалалтын мэдээ</p> <p>Цөмийн энергийн салбарт төрөөс баримтлах бодлого, цөмийн энергийн хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудлууд</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Сар бүр</p> <p>Сар бүр</p> <p>Хагас жил тутам</p> <p>Сар бүр</p> <p>Хагас жил тутам</p>
2.8	Улсын бүртгэлийн асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>Иргэний бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, засварлах, гадаадын иргэдэд ашиглуулах гэмт хэргийн талаарх мэдээ</p> <p>Хүн амын шилжилт, хөдөлгөөний танилцуулга мэдээ</p> <p>Хүн амын төрөлтийн өсөлт , бууралтын мэдээ (аймаг, нийслэлээр) судалгаа танилцуулга</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Хагас жил тутам</p> <p>Улирал бүр</p> <p>Жил бүр</p>
2.9	Мэргэжлийн хяналтын асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>Хяналт шалгалтын ажлын явцад илрүүлсэн, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй зөрчил дутагдлын тухай мэдээ</p> <p>Дотоодын хүнсний үйлдвэрлэлийн болон импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүний хяналт, худалдаа үйлчилгээний хяналт, эм биобэлдмэлийн хяналт, шалгалтын талаарх мэдээ</p> <p>Химийн хортой бодис, тэсэрч дэлбэрэх болон мансууруулах бодис,</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Хагас жил тутам</p>

		<p>тэсэлгээний хэрэгслийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, ашиглалтын тухай мэдээ.</p> <p>Тэсэрч, дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих хуулийн хэрэгжилтийн тухай мэдээ</p> <p>Ашигт малтмалын хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, уурхайн талбайн нөхөн сэргээлтийн мэдээ</p> <p>Амьдрах орчны аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаарх мэдээ</p> <p>Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт, үндэсний аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөндноцтой хохирол учруулсан хэрэг зөрчлийн талаарх мэдээ</p> <p>Эдийн засгийн томоохон төслүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд үндэсний жижиг дунд үйлдвэрүүдийг хоршуулан ажиллуулж буй тухай мэдээ</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Сар бүр</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Жил бүр</p>
2.10	Онцгой байдлын асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>Гал, усны аюул, ган, зуд зэрэг байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, химийн хорт бодисын болон ионжуулагч цацрагийн үүсгүүрийн алдагдал, хүн, малын гоц халдварт өвчний дэгдэлт, тархалт, тэдгээрийг арилгахаар авч хэрэгжүүлж буй ажил, үр дүнгийн тухай</p> <p>Цаг үеийн нөхцөл байдлын тухай</p> <p>Стратегийн ач холбогдолтой барааны нөөц бүрдүүлэлт, эргэлтийн мэдээ</p> <p>Гал түймэр, газар хөдлөлт, цаг уурын аюулт үзэгдэл зэрэг байгалийн гамшиг, түүний хор уршиг, хохирлын мэдээ</p> <p>Гал үер ус, байгалийн гамшигүйлдвэрлэлийн гэнэтийн осол,хүн малын халдварт өвчний цагийн байдал</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай, танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Тухай бүр 7 хоног тутам</p> <p>Хагас жил тутам Жил бүр</p> <p>Хоног тутам</p>

2.11	Стандартчлалын төв байгууллага	<p>Монгол улсын үндэсний стандартыг олон улсын стандартын түвшинд нийцүүлж байгаа талаарх мэдээ (салбар тус бүрээр)</p> <p>Монгол улсад мөрдөгдөж буй олон улсын стандартын талаарх мэдээ (салбар тус бүрээр)</p>	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
Гурав: Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн харъяа газрууд				
3.1	Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	<p>Олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон тухай мэдээ</p> <p>Гадаад орнуудад Монгол Улсын иргэн гэмт халдлагад өртсөн, сураггүй болсон тухай мэдээ</p> <p>Хөрш орнууд болон дэлхийн улс төрийн бодлогыг тодорхойлогч гадаад орнуудаас манай улсын талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа тэдгээрт гарсан өөрчлөлт, цаашдын хандлага</p> <p>Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, улс төр, эдийн засаг, нийгмийн байдалд гарч байгаа чухал үйл явдлууд, тэдгээрийн талаар манай улсын баримталж буй бодлогын тухай мэдээ</p> <p>Гадаад орнуудад буй манай иргэдээс үйлдсэн гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэсэн болон ял эдэлж байгаа тухай мэдээ</p> <p>Төр засгийн түвшинд гадаад бодлого, олон улсын тулгамдсан асуудлаарх Монгол улсын байр суурь</p> <p>Гадаад худалдаа, Гадаадын хөрөнгө оруулалтын мэдээ</p> <p>Үйлдвэр, уул уурхай, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт байгуулсан, нэгдэн орсон Монгол улсын Олон улсын гэрээний тухай танилцуулах мэдээ</p> <p>Алт, зэс, ноолуур, нефть зэрэг стратегийн гол бүтээгдэхүүний зах зээлийн үнэ, хандлага</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Улирал тутам</p> <p>Улирал тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Улирал тутам</p> <p>Улирал тутам</p> <p>Долоо хоног тутам</p>
3.2	Монгол улсын	Засгийн газрын гадаад, дотоодын өр, зээл, гаргасан бондын хэмжээ,	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил

	санхүү, эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги, төлөвлөлт, төсөв сангийн асуудал эрхлэх төрийн захиргааны төв байгууллага	<p>хугацаа, хүү, төлсөн шимтгэл, бонд гаргасан байгууллагууд болон засгийн газрын нийт өрийн хэмжээний дотоодын нийт бүтээгдхүүнд эзлэх хувь, зээлийн зарцуулалтын мэдээ</p> <p>Засгийн газрын шугамаар олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүд болон хэрэгжүүлж дуусах хугацааны мэдээлэл</p> <p>Засгийн газрын гадаад өр, түүний барагдуулалтын мэдээ</p> <p>Гадаад орнууд, олон улсын байгууллагуудаас манайд өгсөн буцалтгүй тусламжийн хэмжээ, зориулалт, зарцуулалтын товч тайлан</p> <p>Монгол Улсын хүний хөгжлийн сан, төрийн сан, төрийн банкны үйл ажиллагааны мэдээ</p> <p>Монгол Улсын төсвийн орлого, зардлын мэдээ, Засгийн газрын хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн мэдээ</p> <p>Инфляци, үнийн өсөлтийг тогтворжуулах, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах арга хэмжээнүүд</p> <p>Эдийн засгийн томоохон төслүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд үндэсний жижиг дунд үйлдвэрүүдийг хоршуулан ажиллуулж буй тухай мэдээ</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p>
3.2.1	Татварын асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>1. Гададын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн төсөвт оруулсан татварын мэдээлэл</p> <p>2. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт, нэгдсэн болон салбар бүрээр</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Улирал бүр</p> <p>Улирал бүр</p>
3.2.2	Гаалийн асуудлыг хэрэгжүүлэх	<p>1. Гаалийн хяналтаар илрүүлсэн, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө учруулж болзошгүй хэрэг, зөрчлийн мэдээ</p> <p>2. Түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг хууль бусаар гадаадад гаргаж буй тохиолдлын тухай мэдээ</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p>

	чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>3. Гаалийн статистикийн мэдээ</p> <p>4. Улсын хилээр оруулж, гаргасан галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт, цацраг идэвхт бодисын тухай мэдээ, судалгаа</p> <p>5. Монгол Улсын экспорт, импортын гол нэрийн барааны мэдээ</p> <p>6. Монгол улсаас экспортлосон, импортлосон бүтээгдэхүүн (нэр төрөл бүрээр)-ий мэдээ</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Сар бүр</p> <p>Улирал бүр</p> <p>Өдөр бүр</p> <p>Улирал бүр</p>
3.3	Хууль зүй, Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	<p>1. Улсын хэмжээнд гарсан тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар хийсэн судалгааны ажлын дүн</p> <p>2. Монгол Улсад хууль бусаар оршин сууж байгаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн динамик үзүүлэлт, тэдний асуудлыг шийдвэрлэсэн тухай ажлын тайлан</p> <p>3. Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй гаднын хүмүүнлэгийн болон шашны байгууллагуудын тоо, үйл ажиллагааны чиглэл, байршил</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Улирал бүр</p> <p>Хагас жил тутам</p>
3.3.1	Цагдаагийн асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>1. Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэргийн тоо, тэдгээрийн төрөл, хүн амины санаатай болон онц хүнд, зохион байгуулалтай гэмт хэргийн тухай мэдээ</p> <p>2. Цагдаагийн байгууллагын өдөр тутмын мэдээ</p> <p>3. Дотоодын цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, ноцтой зөрчлийн мэдээ</p> <p>4. Эрэн сурвалжлагдаж буй хүн, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, химийн, цацраг идэвхт бодис олж тогтоосон, эдгээртэй холбоотой гэмт хэргийн мэдээ, тайлан</p>	<p>Шуурхай мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p>

		<p>5. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, тарианы хууль бус эргэлтийн эсрэг авч буй арга хэмжээний тухай мэдээ, тайлан.</p> <p>6. Хүний наймаа, мөнгө угаах, үндэстэн дамнасан гэмт хэргүүдийн эсрэг авч буй арга хэмжээний тухай мэдээ, тайлан.</p> <p>7. Улсын хэмжээнд үйлдэгдсэн бүртгэгдсэн гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн нэгдсэн мэдээ</p> <p>8. Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлсэн ажлын товч тайлан</p> <p>9. Хоногийн хугацаанд нөхөн илрүүлсэн онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэг, цагдаагийн албадаас зохион байгуулж буй нэгдсэн болон тусгай арга хэмжээ,</p> <p>10. Улсын онц чухал объектын хамгаалалтын нөхцөл байдлын тухай мэдээлэл</p> <p>11. Улсын хэмжээнд хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хүнд болон зохион байгуулалттай гэмт хэрэг, зам тээврийн ослын мэдээ</p> <p>12. Улсын онц чухал объектын хамгаалалтын цагийн байдал, хоногт гарсан зөрчлийн талаар</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p>	<p>Сар бүр</p> <p>Жил бүр</p> <p>Сар бүр</p> <p>Сар бүр</p> <p>Тухай бүр</p> <p>7 хоног тутам</p> <p>Хоног тутам</p> <p>Хоног тутам</p>
3.3.2	Хил хамгаалах асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	<p>Улсын хилийн цагийн байдал, хилийн дэглэмийн зөрчлийн мэдээ</p> <p>Хилийн цэргийн анги, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, ноцтой зөрчлийн мэдээ</p> <p>Улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн гадаадын иргэдийн судалгаа</p> <p>Улсын хилийн боомтоор нэвтэрсэн гадаад, дотоодын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний мэдээ, судалгаа</p> <p>Улсын хил хамгаалалтын цагийн байдал, хилийн болон хилийн дэглэмийн зөрчлийн талаарх мэдээ</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ, Танилцуулах тойм мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Улирал бүр</p> <p>Хоног тутам Хагас жил тутам</p> <p>Хоног тутам</p>
3.3.3	Шүүхийн	Хорих газарт үйлдэгдсэн гэмт хэрэг, ноцтой зөрчлийн мэдээ	Шуурхай мэдээ	Тухай бүр

	<p>шийдвэр гүйцэтгэх асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага</p>	<p>Хорих газраас бүлэг, зохион байгуулалттай болон хүч хэрэглэн оргосон хоригдол, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон ялтны мэдээ</p> <p>Хүнд, онц хүнд гэмт хэрэгт хорих ял шийтгэгдсэн ялтан хугацаанаас өмнө суллагдсан тухай мэдээ</p> <p>Хорих байгууллагын гүйцэтгэх ажлын мэдээ</p> <p>Хорих газраас оргосон болон олж баривчилсан ялтны мэдээ</p> <p>Монгол Улсын хуулиар шийтгэгдэн ял эдэлж байгаа гадаадын иргэдийн тухай мэдээ</p> <p>Хорих ангиудын хамгаалалтын цагийн байдал, хорих ангиудад үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээ</p>	<p>Шуурхай мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Улирал тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хоног тутам</p>
3.3.4	<p>Гадаадын иргэн, харьяатын асуудлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага</p>	<p>Гадаадын иргэдэд үрчлэгдсэн болон гэр бүл болсон, гадаадад гарсан монгол иргэдийн судалгаа</p> <p>Монгол Улсын харьяат бологсод болон харьяатаас гарагсдын мэдээ</p> <p>Төлөөлөгчийн газраа шинээр нээсэн гадаадын болон олон улсын төрийн бус байгууллагуудын судалгаа-мэдээ</p> <p>Харьяалалгүй хүмүүсийн мэдээ</p> <p>Монгол Улсад байнга, хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, цагаач иргэдийн судалгаа</p> <p>Монгол Улсад ажил үйлчилгээ явуулж байгаа гадаадын иргэдийн тухай мэдээлэл</p> <p>Гадаадын иргэдийн холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн мэдээболон албадан гаргасан иргэдийн мэдээ</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p>	<p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Улирал тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Хагас жил тутам</p> <p>Тухай бүр</p>
		<p>Монгол орны байгаль орчны төлөв байдалд гарч буй өөрчлөлт</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Жил бүр</p>

